БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР
Ч.ТӨГСДЭЛГЭР

АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖ ТӨЛӨВЛӨХ ДААЛГАВАР

2025 оны 01 сарын 16 өдөр Дугаар:**2025/00-049** Улаанбаатар хот

1	Авто зам, замын байгууламжийн байршил тогтоосон шийдвэр	Нийслэлийн Замын хөгжлийн газрын 2024 оны 12 дугаар сарын 17-ний өдрийн 03/3104 дугаартай албан бичиг, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 16-ний өдрийн А/1477 дугаартай захирамжийг үндэслэв.
2	Эзэмшигчийн нэр, авто зам, замын байгууламж, зогсоолын байршил, хэмжээ	**Нийслэлийн Замын хөгжлийн газар** Сонгинохайрхан, 10 дугаар хороо, Зүүн баян уулын 36 дугаар гудамжнаас 32 дугаар гудамж хүртэлх 210 м авто зам, замын байгууламж
3	Дагаж мөрдөх ерөнхий төлөвлөгөө, гудамж замын сүлжээний төлөвлөлт	Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг, Баянхошуу нэгж хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө
4	Авто зам, замын байгууламжийн ангилал, зэрэглэл	Нийслэлийн зам Нутаг дэвсгэрийн туслах гудамж зам
5	Хийц, бүтээц	Бүтээц, хийцлэлийг төслөөр сонгох. /МУ-д хүчин төгөлдөр мөрдөгдөж буй норм, норматив нийцүүлэх/
6	Авто замын бүрэлдэхүүн:	Авто замын тухай хуулийн 16 дугаар зүйлийг хангах
	– Авто замын зурвас газар	Авто замын зурвас газрын өргөнийг норм стандартад нийцүүлэн тооцох. Барилгажилт хүртэлх шугамыг нормын дагуу тооцож зураг төсөлд тусгах
	– Зорчих хэсэг	Авто зам зорчих хэсэг 2 эгнээтэй байх, зорчих хэсгийн өргөнийг төслөөр сонгох
	– Замын байгууламж	Тээврийн хэрэгслийн зогсоол, Авто зогсоол ангилал ба ерөнхий шаардлага MNS 5342:2007 стандартыг мөрдлөг болгох. Ус зайлуулах суваг, ногоон зурвас, явган хүний зам, унадаг дугуйн зам, зогсоол, гудамжны гэрэлтүүлгийг нийслэлийн хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хотын стандартын дагуу төлөвлөх
7	Замын байгууламж:	Замын байгууламжийг норм, стандартад нийцүүлэн иж бүрэн төлөвлөх
	– Гүүр, нүхэн гарц	Гадаргуугийн ус, гуу жалга, далан суваг, гол горхитой огтлолцох хэсэгт гүүр, гарц , ус зайлуулах хоолой төлөвлөх.
	– Унадаг дугуй, явган хүний зам	-"Явган хүн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар" MNS6056:2009-стандарт, "Тахир дутуу хүнд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль" /БД 31-101-04/, "Хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлага хангасан зураг төсөл зохиох заавар" /БД 31-112-11/ норм стандартын шаардлага хангасан замын өргөн , орон зайтай байж хүртээмжтэй байдлыг хангана -Унадаг дугуйн зам, зогсоолд MNS 5683: 2016 стандартыг хангуулах -Иж бүрэн гудамж UCS 0901B:2022 "Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавих ерөнхий шаардлага" хотын стандартыг хангуулах - Иж бүрэн гудамж UCS 0903B:2022 "Унадаг дугуйн замын төлөвлөлт, хучилтад тавих ерөнхий шаардлага" хотын стандартыг хангуулах
	– Бусад	Ногоон байгууламж, гудамжны гэрэлтүүлгийн шийдлийг тухайн орчны архитектур, гоо зүйтэй уялдуулж төлөвлөх. Гэрэлтүүлгийг эрчим хүчний хэмнэлттэй шийдлийг сонгон төлөвлөх
8	Архитектур төлөвлөлтийн шаардлага	Архитектур орон зай төлөвлөлтийг Нийслэл хотын онцлог, шаардлага, орц гарц, орчны батлагдсан ерөнхий төлөвлөгөө, төсөл хөтөлбөр, тохижилтын төлөвлөлтийн шийдэлтэй уялдуулан, холбогдох хууль, норм ба дүрмийг мөрдлөг болгох. Гудамж, замыг тээврийн хэрэгсэл, дугуйтай ба явган зорчигчийн хөдөлгөөний эрчимжилт, нутаг дэвсгэрийн зохион байгуулалт, орон зайн зохиомж,

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР
ЕРӨНХИЙ АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБА
2025 оны 01-р сарын 16 өдөр
СБТА 24956 2117401

		барилга байгууламжийн байршил, архитектуртай нь уялдуулан тасралтгүй өсөн хөгжих хөдөлгөөнтэй нэгдсэн систем байхаар төлөвлөх.
9	Хот төлөвлөлтийн онцгой нөхцөл	Одоо байгаа орц гарц, орчны батлагдсан ерөнхий төлөвлөгөө, төсөл хөтөлбөр, тохижилтын төлөвлөлтийн шийдэлтэй уялдуулан, холбогдох хууль, норм ба дүрмийг мөрдлөг болгон төлөвлөх, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан, иргэд богино хугацаанд тохь тухтай зорчих шаардлагад нийцсэн байх. Төлөвлөлтийн талбайд өртсөн газар, барилга байгууламж, нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг нарийвчлан судалж зураг төсөлд тусгах, шаардлагатай үед чөлөөлөх. Нийслэлийн Авто зам, Газрын асуудал эрхэлсэн байгууллагууд болон холбогдох мэргэжлийн байгууллагуудтай зөвшилцсөний үндсэн дээр трассын байгуулалт, загвар зураг батлуулах. Ажлын зургийг инженерийн шугам сүлжээний хариуцсан байгууллагуудтай зөвшилцөж магадлал хийлгэн барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэх, зорчигчийн амрах цэг, дугуйн зогсоол, автобусны эцсийн буудлын тохижилт төлөвлөх, Нийслэл хотоос хэрэгжүүлж буй төсөл хөтөлбүүдийн тухай холбогдох газраас өгсөн мэдээлэл дээр суурилж, шаардлагатай мэдээллийг шинээр цуглуулж тээврийн хэрэгсэл, явган зорчигч, дугуйтай зорчигч нар авто зам, замын байгууламжаар аюулгүй, чөлөөтэй , саадгүй нэвтэрч байхаар уулзвар, гудамж сүлжээний геометрийн параметрүүд нь зөв байхаар тооцоолон төлөвлөх. Уулзвар төлөвлөлтийг мэргэжлийн программ хангамжаар тооцоолон хийх, гэрлэн дохион зохицуулалтай, зохицуулалтгүй уулзвар төлөвлөлтийг ЗХУТ, Тээврийн цагдаагийн алба, НЗХГ-тай зөвшилцөн баталгаажуулах. Гамшгийн онцгой үед гал унтраах тээврийн хэрэгсэл саадгүй нэвтэрч байхаар уулзварын эргэлтийн радиусыг төлөвлөх, Захиалагч байгууллагын үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан авто машины зогсоол төлөвлөлтийг анхаарах.
10	Талбайн өндөржилтөнд тавигдах шаардлага	Улаанбаатар хотын нэгдсэн өндөржилтийн төлөвлөлттэй уялдуулан зураг төсөл боловсруулах. Гадаргуугийн ус зайлуулах арга хэмжээг орчны барилгажилт, газрын хэвгийтэй уялдуулж хамрах талбайн хэмжээнд иж бүрэн шийдэх
11	Инженерийн шугам сүлжээнд тавигдах шаардлага	Трассын дагуу газрын зураглалын тодруулалт хийлгэх, газар доорх болон дээрх шугам сүлжээ болон хийгдэхээр төлөвлөж буй шугам сүлжээний төлөвлөлтийг тодруулсны үндсэн дээр зураг төсөл боловсруулах. Шугам сүлжээтэй огтлолцуулах, шилжүүлэх асуудлыг инженерийн шугам сүлжээний хариуцсан байгууллагаас олгосон техникийн нөхцөлийг үндэслэн шийдвэрлэх. Инженерийн шугам сүлжээний хөндлөн гаргалгаанд зориулж нэвтрэх суваг төлөвлөх
12	Инженерийн бэлтгэл арга хэмжээ (үерийн хамгаалалт, далан, суваг, шуудуу, зайлуулах шугам сүлжээ)	Хөрсний нүүлт, гулсалтаас хамгаалах арга хэмжээ, хөрсний ус зайлуулах шугам сүлжээг тухайн газрын инженер геологи-гидрогеологийн нөхцөлийг иж бүрэн судалсны үндсэн дээр төлөвлөх. Хөрсний шинж чанараас шалтгаалан замын суурийг оновчтой сонгох
13	Барилгажилтын улаан шугам	Магадлал хийлгэсэн ажлын зургийн дагуу 0 тэнхлэг тавиулж барилгын ажлыг эхлүүлэх.
14	Захиалагчийн нэр, хаяг, утас	Нийслэлийн Замын хөгжлийн газар Утас: 11 325385

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР
ЕРӨНХИЙ АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБА
2025 оны 01-р сарын 16 өдөр
СБТ-24958 2117401

Анхааруулга:

1. Зам, замын байгууламжийг барих явцад хүрээлэн буй орчны байгалийн тогтоц, өмнө хийгдсэн тохижилт, зам талбай, ногоон байгууламжийг хамгаалах ба хэрэв хөндвөл нөхөн сэргээх.

2. Төвөгшилтэй зам, замын байгууламжид байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийж, инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн төлөвлөлтийн нэгдсэн шийдлийг гаргах.

3. Зөвшилцсөн трасс болон ажлын зургийг цахим хэлбэрээр Хот байгуулалтын мэдээллийн менежментийн нэгдсэн санд хүлээлгэн өгөх.

4. Зам, замын байгууламжийн шинэчлэх, засварлах шаардлагатай бол энэ тухай эрх бүхий байгууллагын техникийн дүгнэлт (акт), шийдвэрийг даалгаварт хавсаргах.

5. Зам, замын байгууламжийн зураг төслийг боловсруулахдаа даалгаварт заасан нэр, байршил, замын зэрэглэлийг зөрчсөн тохиолдолд зам, замын байгууламжийн трассыг зөвшилцөхгүй болно.

6. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 21-р тогтоолоор батлагдсан "Иж Бүрэн Гудамж" бүлгийн UCS 0903B:2022 "Унадаг дугуйн замын төлөвлөлт, хучилтад тавих ерөнхий шаардлага"; UCS 0901B:2022 "Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавих ерөнхий шаардлага"

7. Авто замын зургийг Монгол улсад мөрдөж буй "Авто зам төсөллөх" ЗЗБНбД 22-004-2016, "Авто зам, гүүрийн зураг төсөл, хайгуулын ажлын жишиг үнэ" БД81-104-02, "Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм" БНбД 30.01.04, Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль" БД31.101.04, "Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар" MNS 6056-2009, "Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам, техникийн шаардлага" MNS 5682:2006, "Авто замын гүүр ба хоолой төсөллөх" БНбД 32-02-12, "Явган хүний зам, талбай төсөллөлт, техникийн шаардлага" MNS 6808:2019, , "Авто зам, замын байгууламж. Унадаг дугуйн замыг төлөвлөхөд тавих ерөнхий шаардлага" MNS 5683:2022, "Авто зам, замын байгууламж болон инженерийн шугам сүлжээний ажлын төсөвт өртгийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төсвийн жишиг нормын дагуу тооцох, магадлалаар оруулан баталгаажуулах, ЗТХ-ийн Сайдын 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 168 дугаар тушаалаар батлагдсан "Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам"-ыг баримталж ажиллах.

ХЯНАСАН
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН
ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА . . . . . Б.ОЮУНТУЯА

БОЛОВСРУУЛСАН
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН
ЗАМЫН ХӨДӨЛГӨӨН, ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН ИНЖЕНЕР. . . . . Б.ДУЛМАА

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР
ЕРӨНХИЙ АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБА
2025 оны 01-р сарын 16 өдөр
СБТ№ 24956 2117401

АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖ ТӨЛӨВЛӨХ ДААЛГАВРЫН СХЕМ ЗУРАГ

(Дугаар:2025/00-049 авто зам, замын байгууламж төлөвлөх даалгаврын хавсралт)

Байршил	Эзэмшигч	Зориулалт
Сонгинохайрхан дүүрэг, 10-р хороо	Нийслэлийн Замын хөгжлийн газар	Авто замын барилга

Масштаб 1:2000 *Тусгаг: 32648* *(Архитектур төлөвлөлтийн даалгаврын хамт хүчинтэй.)*

ТАНИХ ТЭМДЭГ

- *Одоо байгаа барилга*
- *Төлөвлөлтийн хязгаар*
- *Нэгж талбар*
- *Цэвэр усны шугам*
- *Бохирын шугам*
- *Дулааны шугам*
- *Холбооны шугам*
- *Үерийн шугам*

ТОДОРХОЙЛОЛТ

1	*Төлөвлөж буй байршил*
2	*Баянхошууны автобусны эцсийн буудал*
3	*Баянхошуу амбулатори*
4	*264-р цэцэрлэг*
5	*Үерийн далан суваг*

ОЛГОСОН ТАЛБАЙН ТОДОРХОЙЛОЛТ

Зурвас газар (м^2)	~3835
Авто замын урт (км)	~0,21

Эргэлтийн цэгүүдийн солбицол

(Цахим (shp, dwg) хэлбэрээр гаргуулан авч зураг төсөл боловсруулах шаардлагатай.)

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР
БҮРЭН ЭРХТЭЙ АРХИТЕКТУРЫН ЗӨВШӨӨРӨЛ
2025 оны 01-р сарын 16 өдөр
СБТА 24056 2117401

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР Хот байгуулалтын инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтэс	Наадамчдын зам 1200, Арцатын ам, 23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17100 Утас: 72707700, Цахим хуудас: www.ebarilga.ub.gov.mn

БАТЛАВ:
НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ОДБАЯР

АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

Дугаар 24010100178 Улаанбаатар Хот

1	Зураг төсөл боловсруулах үндэслэл	Нийслэлийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 16-ний А/1477 дугаартай захирамж. Нийслэлийн Хот байгуулалт, Хотын стандартын газар 2025/00-049 дугаартай авто зам, замын байгууламжийн архитектур төлөвлөлтийн даалгавар.
2	Байршил	Сонгинохайрхан дүүрэг, 10 дугаар хороо, Зүүнбаян уул 36 гудамжнаас 32 дугаар гудамж хүртэлх авто зам
3	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр
4	Авто замын техникийн ангилал, замын зэрэг	Нутаг дэвсгэрийн туслах гудамж зам
5	Газрын бартаалаг, төвөгшил	Трасс сонголтын үеийн болон замын төсөллөлтийн төвөгшлийг БНбД-ээс харах
6	Замын хучилтын хийц	Хучилтын бүтээцийг тооцоогоор үндэслэнэ.
7	Зураг төсөл зохиох үе шат, хугацаа	1 үе шаттай 2025 он
8	Зураг төслийн байгууллага	Хотын авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй байгууллага.
9	Захиалагч байгууллага	Нийслэлийн Замын хөгжлийн газар
10	Зураг төслийн иж бүрдэл	1. Инженер геодезийн ажлын тайлан 2. Инженер геологийн судалгааны ажлын тайлан 3. Авто зам, замын байгууламжийн ажлын инженерийн нарийвчилсан зураг төсөл 4. Тайлбар бичиг (хучилтын тооцоо, ус зүйн тооцоо, тухайн байршил орчмын байгаль, цаг уурын статистик мэдээ, төслийн шийдэлд онцгой нөлөө үзүүлэх байгаль цаг уурын хүчин зүйлсийн тухай мэдээ, ажлын нэр, тоо хэмжээ, авто зам, замын байгууламжийн зураг төслийн бүрдэл, холбогдох захирамж, техникийн нөхцөл, магадлалын дүгнэлт гэх мэт) 5. Техникийн шаардлага 6. Холбогдох шугам сүлжээний зураг төсөл, төсөв 7. Авто зам, замын байгууламжийн нэгдсэн төсөв 8. Төслийн танилцуулга

11. Онцгой нөхцөл:

- Авто замын зургийг Монгол улсад мөрдөж буй "Авто зам төсөллөх" ЗЗБНбД 22-004-2016, "Авто зам, гүүрийн зураг төсөл, хайгуулын ажлын жишиг үнэ" БД81-104-02, "Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм" БНбД 30.01.04, Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль" БД31.101.04, "Тээврийн хэрэгслийн зогсоол, Авто зогсоол ба ерөнхий шаардлага MNS 5342:2007, "Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар" MNS 6056-2009, "Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэт иргэдэд зориулсан зам, техникийн шаардлага" MNS 56 828 "Авто замын гүүр ба хоолой төсөллөх" БНбД 32-02-12, "Явган хүний зам, талбай төсөллөлт, техникийн шаардлага" MNS 6808:2019, "Авто зам, замын байгууламж болон инженерийн шугам сүлжээний ажлын төсөвт өртгийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төсвийн жишиг нормын дагуу тооцох, магадлалаар оруулан баталгаажуулах, ЗТХ-ийн Сайдын 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 168 дугаар

тушаалаар батлагдсан "Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам" болон бусад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох норм дүрмүүдийг үндэслэх.

- Нийслэлийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/456 дугаар захирамжаар батлагдсан "Нийслэлийн хэмжээнд мөрдөх стандарт, шаардлага UCS 09011B:2020, UCS 0902B:2020, UCS 0903B:2020, UCS 0001-01:2019, UCS 0001-02:2019, UCS 0002-02:2019, UCS 1901B:2020, UCS 4103C:2020, UCS 1404C:2020, UCS 0901B:2020, UCS 0903B:2022-г тус тус мөрдөх.
- Геодезийн хэмжилт зураглалын ажлыг улсын сүлжээний цэгүүдэд тулгуурлан хийх, зам барилгын суурь бэлтгэл ажлын хүрээнд хийгдэх тулгуур цэг байгуулах, замын төлөвлөлтийн дагуу өндрийн болон байрлалын хэмжилт хийж баталгаажуулж газрын хар өндрийг тодорхойлох
- Байр зүйн болон өндрийн хэмжилтийг UTM системд хийх
- Улаанбаатар хотын Ерөнхий төлөвлөгөө, Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага, Улаанбаатар хотын хэсэгчилсэн Ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан зураг төслийг боловсруулах.
- Трасс сонголтыг газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт, инженерийн шугам сүлжээ, одоо байгаа барилга байгууламж, хэтийн хөдөлгөөний эрчмийг анхаарч үзэх.
- Гудамж замын төлөвлөлттийн талаар танилцуулга, мэдээллийг тайлбар бичигт тусгах, захиалагч байгууллагад урьдчилан танилцуулах.
- Инженер геологийн судалгаа хийж, хэсэг бүрт хөрсний геотехникийн үзүүлэлтүүдийг нарийвчлан тогтоон замын байгууламжийн бүтээцийг тооцоогоор оновчтой сонгох.
- Хөрсний шинж чанараас шалтгаалан замын суурийг оновчтой сонгох.
- Авто замын үндсэн элементүүд болох авто замын зорчих хэсэг, явган хүний зам, унадаг дугуйн зам /*төслөөр*/, уулзвар төлөвлөлт, гэрлэн дохио, нийтийн тээвэр болон автомашины зогсоол, явган хүний гарц /нэг болон хоёр түвшин гарцыг төслөөр/, ногоон байгууламж, тусгаарлах зурвас, гадаргуугийн усыг зайлуулах байгууламж болон хөндөгдөж буй шугам сүлжээ зэргийг хамруулан ажлын зургийг иж бүрнээр төсөллөх, план зурагт инженерийн шугам сүлжээний өөрчлөлт газрын нөлөөлөл, орчны мэдээллийг нэгтгэн боловсруулж үзүүлсэн байна.
- Явган хүний зам, ногоон байгууламж, гэрэлтүүлгийн өнгө төрхийг тухайн орчны харагдах нөхцөл байдалтай уялдуулж төлөвлөх.
- Хөндлөн огтлолыг орчны нөхцөлтэй уялдуудан төлөвлөх, барилга байгууламж, айлууд руу орох орц гарцны шийдлийг оновчтой хийж хөндлөн огтлолыг төлөвлөх
- Гадаргуугийн ус зайлуулалтыг ус хураах талбайн хэмжээнд тооцоо хийж төлөвлөх, ус зайлуулах байгууламжийг цогцоор нь шийдэх. Геодези Усны Барилга Байгууламж ОНӨААТҮГ-тай зураг төслийг зөвшилцөх
- Инженерийн шугам сүлжээний байгууллагуудын техникийн нөхцөлийг тусгах, ажлын зураг боловсруулах, холбогдох байгууллагатай зөвшилцөх, ажлын зургийг батлуулах
- Авто замын төлөвлөлтийг огтлолцож буй болон холбогдож буй бүх талын замын төлөвлөлттэй уялдуулах, авто замын трассын дагууд суваг, шуудуу, жалга дайрсан үед шаардлагатай тохиолдолд гүүр, гүүрэн гарц төлөвлөх
- Хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган замын дагууд тэмдэг, тэмдэглэгээ, хөдөлгөөн зохицуулалтын тоноглолыг иж бүрэн байдлаар зураг төсөлд тусгах
- Уулзвар, хөдөлгөөн зохион байгуулалтыг цогц шийдвэрлэх.
- Авто замын трассад орсон барилга байгууламж, нийтийн эзэмшлийн эд зүйлсийг нарийвчлан гаргаж тайлбар бичигт газар чөлөөлөлтийн талаар тусгайлан оруулах, зургийн шийдлийн дагуу зайлуулах бол тусгах.
- Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчинг бүрдүүлэх зорилгоор зам талбайн болон хөдөлгөөн зохион байгуулалтын арга хэмжээ, тоноглол, замын холбогдох байгууламжуудыг тусгасан байх.
- Авто замын гэрэлтүүлгийг төлөвлөлт хийж, хүчин чадлыг тодорхойлсны дараа тухайн зөвлөх нь "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК руу бие даан хандаж /өргөдлийн маягт бөглөх/ техникийн нөхцөл авч /эх үүсвэрийг тодруулах/ ажлын зургийг боловсруулах.
- Авто замын гэрэлтүүлгийг эрчим хүчний хэмнэлттэй, шар тусгалтай чанарын шаардлага хангасан "LED" технологиор шийдвэрлэх.
- Зураг төслийг дараах масштабтайгаар боловсруулна. Үүнд:

Дэвсгэр зураг		1:500
Дагуу огтлол	хэвтээ	1:1000
	босоо	1:100
Хөндлөн огтлол		1:100

Уулзвар, огтлолцол	1:500
Бүтээц	1:20

- Авто зам төлөвлөлтийн шатанд буюу авто замын план зургийг Нийслэлийн Хот байгуулалт,Хотын стандартын газар, Нийслэлийн Замын хөгжлийн газар, Нийслэлийн Газар Зохион Байгуулалтын Алба, Геодези, Усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ-тай тус тус зөвшилцсөний үндсэн дээр нарийвчилсан зураг төсөлд холбогдох газруудаас санал аван зураг төслийг баталгаажуулах.
- Тухайн зам, замын байгууламжийн үндсэн элементүүдийг Нийслэлийн Замын бүртгэл мэдээллийн сангийн бүтэц бүрэлдэхүүний дагуу мэдээллийг боловсруулж цахим хэлбэрт замын шинж чанарын мэдээллийг үүсгэж "хотын замын мэдээллийн сан"-д оруулах, баталгаажуулах /хавсралтын дагуу боловсруулах/
- Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээг Хот байгуулалт, Хөгжлийн газрын "ТООН ЗУРГИЙН ТАНИХ ТЭМДЭГ"-ийн дагуу боловсруулсан байна.
- Авто зам, замын байгууламжийн ажлын зураг, тайлбар бичиг, инженер геологи, геодезийн хэмжилтийн тайлан, техникийн шаардлага, орчны тоймыг харуулсан 3 хэмжээст зураг, төслийн танилцуулга бусад холбогдох бичиг баримтыг эх хувь 1ш, хуулбар хувь 2ш (хуулбар хувийг өнгөтөөр хувилж авчрах), тоон хэлбэрээр /DWG болон PDF/ болон зургийн 1% иж бүрдлийг архивын баримт бичиг хадгалах стандартын дагуу бэлтгэн хүлээлгэж өгөх, орон зайн болон орон зайн бус мэдээллийг тоон хэлбэрээр /DWG болон PDF/ мэдээллийн санд батлагдсан загварын дагуу хүлээлгэж өгөх.

ХЯНАСАН:
НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА — В.МЯГМАР

БОЛОВСРУУЛСАН:
НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН — Г.УНДРАМ

2025 оны 01 дугаар сарын 02-ны өдөр

Нийслэлийн Замын хөгжлийн газар

Газрын байршил	Газрын зориулалт
Баянгол дүүрэг, 29 дүгээр хороо	Авто зам, Замын байгууламж

2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн .....дугаартай
ажлын даалгаврын хавсралт 24010100178

Таних тэмдэг:

Шинээр төлөвлөж буй авто зам

Хянасан:
НЗХГ-ын БТХ-ийн дарга ...../В.Мягмар/

Боловсруулсан:
НЗХГ-ын БТХ-ийн мэргэжилтэн ...../Г.Ундрам/

АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСЛИЙГ НИЙСЛЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САНД БҮРТГЭЖ АВАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА /Загвар зураг/



АВТО ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН ТӨСЛИЙГ НИЙСЛЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САНД БҮРТГЭЖ АВАХ ЗУРГИЙН ДАВХРАГЫН ТАВИГДАХ ШААРДЛАГА

ДАВХРГЫН НЭР	ЗУРААСНЫ ТӨРӨЛ	ХЭРЭГЛЭХ ХҮРЭЭ
1		Замын тэнхлэг
2		Авто зам
3		Явган зам
4		Дугуйн зам
5		Ногоон байгууламж
6		Замын хашлага
7		Хучилттай хөвөө
8		Замын далан
9		Улаан шугам
10		Чиглүүлэгч хавтан
21		Хэвтээ тэмдэглэгээ
22	(Point)	Заах тэмдэг
23	(Point)	Анхааруулах тэмдэг
24	(Point)	Хориглох тэмдэг
25	(Point)	Дараалын тэмдэг
26	(Point)	Мэдээллэх тэмдэг
27	(Point)	Нэмэлт тэмдэг
31		Зааглах хашлага
32		Туузан хашлага
33	(Point)	Замын гэрэлтүүлэг
34	(Point)	Гэрлэн дохио
35		Хурд сааруулагч
36		Ус зайлуулах шугам
41		Гүүр
42		Хоолой
43		Авто машины нүхэн гарц
44		Явган хүний нүхэн гарц
45		Орц гарц
70	Text	Бичиглэл

Тайлбар:
Авто зам, замын байгууламж болон тэмдэг тэмдэглэгээ, хоолойгоон зохицуулалтын тоноглол гэх мэт элементүүдийн тоон үзүүлэлтийг (ш, у/м, м²) гэсэн хэтжигдэхүүнээр мэдээллийн санд цахимаар бүртгэлжүүлж байгаатай холбоотой автокад файлыг дээрх шаардлагад нийцүүлэн хүлээж авна.